СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/216-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: “Пийк Ом Аудит” ХХК Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НА	Нийцлийн аудит
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАГ	Төрийн аудитын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдах авах тухай
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.БҮРЭНЖАРГАЛ ТАНАА

2024.2.23 № СЭА-2024/216-НА-СЭА-НИЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд “Бороо гоулд” ХХК-иас 6,170.0 мянган төгрөгийн камер, төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

C18020136

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,027,460.29	120,644,744.89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,881,572.29	118,956,574.09
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,881,572.29	118,956,574.09
3121	Төгрөг	15,881,572.29	118,956,574.09
31211	Төрийн сангийн харилцах	15,881,572.29	118,956,574.09
35	БАРАА МАТЕРИАЛ	20,145,888.00	1,688,170.80
354	Хангамжийн материал	20,145,888.00	1,688,170.80
3546	Хүнсний материал		1,688,170.80
3547	Бусад хангамжийн материал	20,145,888.00	
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	742,616,665.29	717,645,177.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	742,616,665.29	717,645,177.83
392	Биет хөрөнгө	525,713,831.79	500,756,927.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	520,665,518.05	520,665,518.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-100,178,112.48	-124,324,632.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,788,648.64	46,958,648.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,215,371.88	-20,544,386.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,579,191.90	36,855,391.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,818,476.72	-11,207,005.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	80,786,053.00	80,786,053.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-22,936,618.72	-28,475,659.36
39217	Ном	43,000.00	43,000.00
393	Биет бус хөрөнгө	216,902,833.50	216,888,249.99
39301	Программ хангамж	1,625,000.00	1,625,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-354,166.50	-368,750.01
39303	Бусад биет бус хөрөнгө	215,632,000.00	215,632,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	778,644,125.58	838,289,922.72
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	778,644,125.58	838,289,922.72
51	Засгийн газрын хувь оролцоо	778,644,125.58	838,289,922.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	332,071,103.00	332,071,103.00
51101	Өмч: - төрийн	332,071,103.00	332,071,103.00
512	Хуримтлагдсан үр дүн	-107,007,673.07	-47,361,875.93
5121	Өмнөх үеийн үр дүн	-107,007,673.07	-107,007,673.07
5122	Тайлант үеийн үр дүн		59,645,797.14
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	553,580,695.65	553,580,695.65
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	778,644,125.58	838,289,922.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,483,594,062.06	996,406,737.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	811,144,162.84	10,130,870.00
120	Нийтлэг татварын бус орлого	811,144,162.84	10,130,870.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,880,809.64	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,880,809.64	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	752,782,746.18	6,170,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	32,480,607.02	3,960,870.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	672,449,899.22	986,275,867.22
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	600,482,500.00	933,299,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		933,299,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	600,482,500.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,967,399.22	52,976,267.22
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,967,399.22	52,976,267.22
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	704,949,936.48	936,760,940.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	704,949,936.48	936,760,940.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	704,949,936.48	923,248,040.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,867,548.41	588,013,094.13
210101	Үндсэн цалин	347,124,586.29	375,752,147.42
210102	Нэмэгдэл	104,516,672.92	196,074,592.81
210104	Урамшуулал	6,226,289.20	16,186,353.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,164,998.94	77,625,228.87
210201	Тэтгэврийн даатгал	34,747,127.29	53,384,073.87
210202	Тэтгэмжийн даатгал	11,024,909.27	6,280,573.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,673,874.95	5,088,821.56
210204	Ажилгүйдлийн даатгал	967,987.43	1,184,560.11
210205	Эрүүл мэндийн даатгал	9,751,100.00	11,687,199.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,297,199.58	47,325,967.22
210301	Гэрэл, цахилгаан	4,514,878.86	7,731,044.03
210302	Түлш, халаалт	23,224,544.28	31,308,554.19
210303	Цэвэр, бохир ус	5,557,776.44	8,286,369.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	20,145,888.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		20,145,888.00

2105	Норматив зардал	95,247,749.02	105,778,604.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	220,000.00	
210502	Хоол, хүнс	83,022,530.00	105,778,604.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,005,219.02	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,841,400.00	5,650,300.00
210604	Урсгал засвар	3,841,400.00	5,650,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	949,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	949,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,478,540.53	78,708,957.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,224,200.00	34,054,570.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,207,450.00	6,236,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,046,890.53	38,417,687.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		13,512,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		13,512,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		13,512,900.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	778,644,125.58	59,645,797.14
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	778,644,125.58	59,645,797.14

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	672,449,899.22	986,275,867.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	672,449,899.22	986,275,867.22
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	600,482,500.00	933,299,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		933,299,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	600,482,500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,967,399.22	52,976,267.22
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,967,399.22	52,976,267.22
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	656,568,326.93	875,924,665.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	656,568,326.93	875,924,665.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	656,568,326.93	862,411,765.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,861,548.41	588,013,094.13
210101	Үндсэн цалин	317,298,936.58	375,752,147.42
210102	Нэмэгдэл	133,305,544.63	196,074,592.81
210104	Урамшуулал	7,257,067.20	16,186,353.90

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,164,998.94	77,625,228.87
210201	Тэтгэврийн даатгал	34,747,127.29	53,384,073.87
210202	Тэтгэмжийн даатгал	10,731,671.65	6,280,573.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,959,900.00	5,088,821.56
210204	Ажилгүйдлийн даатгал	975,200.00	1,184,560.11
210205	Эрүүл мэндийн даатгал	9,751,100.00	11,687,199.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,297,199.58	47,325,967.22
210301	Гэрэл, цахилгаан	4,514,878.86	7,731,044.03
210302	Түлш, халаалт	23,224,544.28	31,308,554.19
210303	Цэвэр, бохир ус	5,557,776.44	8,286,369.00
2105	Норматив зардал	83,022,530.00	107,466,775.20
210502	Хоол, хүнс	83,022,530.00	107,466,775.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,174,100.00	5,650,300.00
210604	Урсгал засвар	5,174,100.00	5,650,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,110,000.00	2,307,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.00	2,307,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,937,950.00	34,022,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,737,950.00	27,786,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200,000.00	6,236,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		13,512,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		13,512,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		13,512,900.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,881,572.29	110,351,201.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		7,276,200.00
	Дотоод эх үүсвэрээр		7,276,200.00
222001	Тоног төхөөрөмж		7,276,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-7,276,200.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	15,881,572.29	103,075,001.80
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		15,881,572.29
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		118,956,574.09

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,071,103.00	553,580,695.65	-107,007,673.07	778,644,125.58

11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			59,645,797.14	59,645,797.14
19	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,071,103.00	553,580,695.65	-47,361,875.93	838,289,922.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,002,157,367.22	883,200,793.13	118,956,574.09	88.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,002,157,367.22	883,200,793.13	118,956,574.09	88.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	988,644,467.22	869,687,965.42	118,956,501.80	88.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	687,938,500.00	588,013,094.13	99,925,405.87	85.5
210101	Үндсэн цалин	467,775,000.00	375,752,147.42	92,022,852.58	80.3
210102	Нэмэгдэл	203,360,400.00	196,074,592.81	7,285,807.19	96.4
210104	Урамшуулал	16,803,100.00	16,186,353.90	616,746.10	96.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,992,800.00	77,625,228.87	8,138,823.43	90.3
210201	Тэтгэврийн даатгал	58,474,800.00	53,384,073.87	5,090,726.13	91.3
210202	Тэтгэмжийн даатгал	6,879,400.00	6,280,573.37	598,826.63	91.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,503,900.00	5,088,821.56	415,078.44	92.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,375,600.00	1,184,560.11	191,039.89	86.1
210205	Эрүүл мэндийн даатгал	13,759,100.00	11,687,199.96	2,071,900.04	84.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,325,967.22	47,325,967.22		100.0
210301	Гэрэл, цахилгаан	7,731,044.03	7,731,044.03		100.0
210302	Түлш, халаалт	31,308,554.19	31,308,554.19		100.0
210303	Цэвэр, бохир ус	8,286,369.00	8,286,369.00		100.0
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Норматив зардал	117,981,600.00	107,466,775.20	10,514,824.80	91.1
210502	Хоол, хүнс	117,981,600.00	107,466,775.20	10,514,824.80	91.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,650,300.00	5,650,300.00		100.0
210604	Урсгал засвар	5,650,300.00	5,650,300.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,078,900.00	2,078,900.00	0.00	111.0

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,078,900.00	2,078,900.00	0.00	111.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,676,400.00	41,299,000.00	377,400.00	99.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,439,700.00	35,062,300.00	377,400.00	98.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,236,700.00	6,236,700.00		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,512,900.00	13,512,900.00		100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,512,900.00	13,512,900.00		100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,512,900.00	13,512,900.00		100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,002,157,439.51			
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	933,299,600.00	933,299,600.00		
131001	Улсын төсвөөс санхүүжих	933,299,600.00	933,299,600.00		
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,976,267.22	52,976,267.22		
132001	Орон нутгийн төсвөөс	52,976,267.22	52,976,267.22		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,881,572.29	15,881,572.29	-15,881,572.29	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		118,956,574.09	-118,956,574.09	

3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэг нь *"Эрүүл аюулгүй таатай эко орчинд зөвөөр үлгэрлэж сайн хүн болгон төлөвшүүлнэ"* гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Тус байгууллага нь дараах чиг үүрэгтэй ажилласан байна. Үүнд:

- Тохилог орчинд суралцах,
- Хүмүүжлийн зөв дадал олгох,
- Өөртөө итгэлтэй үнэнч шударгаар үлгэрлэх,
- Хүүхэд бүрийн эрхийг дээдэлж тоглох,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд шинэчлэн батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*

- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх,худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяр хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,645.8 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,881.6	118,956.6	103,075.0
Авлага			
Бараа материал	20,145.9	1,688.2	(18,457.7)
Үндсэн хөрөнгө	742,616.7	717,645.2	(24,971.5)
Нийт хөрөнгө	**778,644.1**	**838,289.9**	**59,645.8**
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	778,644.1	838,289.9	59,645.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**778,644.1**	**838,289.9**	**59,645.8**

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 118,956.6 мянган төгрөг болж 103,075.0 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх "*Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй*" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 1,688.2 мянган төгрөг болж 18,457.7 мянган төгрөгөөр буурсан нь БШУЯ-наас 3,960.8 мянган төгрөгийн тоглоом наадгай үнэ төлбөргүй авч, төсвийн хөрөнгөөр 119,820.8 мянган төгрөгийн худалдан авалт хийж, үйл ажиллагаанд 142,239.3 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 717,645.2 мянган төгрөг болж 24,971.5 мянган төгрөгөөр буурсан нь "Бороо гоулд" ХХК-иас 6,170.0 мянган төгрөгийн камер, төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 7,276.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, тайланд онд 38,417.7 мянган төгрөгийн элэгдэл тооцсоноос тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 931,614.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 57,840.7 мянган төгрөг нийт 989,454.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 160,307.0 мянган төгрөгөөр буюу цалин хөлсийг 118,095.7 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 15,359.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 7,459.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 19,392.7 мянган төгрөгөөр тус тус буруулж нийт 829,147.7 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд төсөвт 3 удаа өөрчлөлт орж 11 дүгээр сард цалин хөлсийг 144,682.3 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 3,458.8 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 2,984.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 21,883.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж улсын төсвөөс 933,299.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 52,976.2 мянган төгрөгийн санхүүжилт, урьд оны үлдэгдлээс 15,881.5 мянган төгрөг зарцуулахаар төсвийг нийт 1,002,157.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,002,157.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 883,201.0 мянган төгрөгийг зарцуулж, 118,956.4 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 883,201.0 мянган төгрөг буюу 88.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 95,227.6 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 23,728.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр зориулалт	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	3,193.4	3,193.4	-	100.00
2	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	117,981.6	107,466.8	10,514.8	91.09
3	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	4,940.0	4,940.0	-	100.00
4	81823	Боловсролын байгууллагын багш,	3,118.4	2,741.0	377.4	87.90
5	81834	Боловсролын стандарт, сургалты	638,861.4	531,454.5	107,406.9	83.19
6	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	181,086.3	180,429.0	657.3	99.64
7	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	52,976.3	52,976.3	-	100.00
Нийт			**1,002,157.4**	**883,201.0**	**118,956.4**	**88.1**

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны *"Чиглэл хүргүүлэх тухай"* албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ 107,899.8 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Пийк Ом Аудит" ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг компанийн захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Пийк Ом Аудит" ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 704,949.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,049.5 мянган

төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын 1 цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэггүй, зах зээл хомс гэх шалтгаанаар хүнсний худалдан авалтыг нээлттэй зарлаж, үнийн харьцуулалт хийлгүйгээр иргэдээс болон "Шанзан ташуур" ХХК, "Мөнх Би То Са" ХХК, "Шанддов" ХХК, "Уужим хараа" ХХК , " Тулга өргөжих" ХХК-иудтай гэрээ байгуулан шууд худалдан авсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "*Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална*", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн 2: *"Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг"* гэж заасныг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу ил тод нээлттэй зохион байгуулж, гүйцэтгэх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

"Пийк Ом аудит" ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 214 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивээгүй 1,532.8 мянган төгрөгийн, шилэн дансны цахим цэсэнд мэдээлэл хоцроож мэдээлсэн зэрэг зөрчил илэрч 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1		1		100.0
Албан шаардлага	1	1,532.8	1	1,532.8	100.0
Нийт дүн	**2**	1,532.8	**2**	1,532.8	**100.0**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт "*2022 оны санхүүгийн тайланд "**Зөрчилгүй**", " **Итгэл үзүүлсэн**", "**Түүвэрт хамрагдсан**" гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно*" гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал нягтлан бодогч С. Оюун- Эрдэнэд нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу 875.3 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:*", 15.1.3 : "*Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 20,189.7 мянган төгрөгийн алдааг залруулаа.Үүнд:

- Санхүүгийн тайланд цалингийн зардлын 4,960.8 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*" гэсэн заалтыг,
- Худалдан авсан 7,952.6 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг төлбөр хүлээн авагчийн нэрээр бус хамаарал бүхий этгээд, өөр аж ахуйн нэгжийн нэрээр орлого авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*" гэсэн заалтыг,
- Худалдан авсан 7,276.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээнд бус бараа материалын зардлаар тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3-р хавсралт дахь "Мөнгөн гүйлгээний тайлан" 6.9-д "*Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ нь урт хугацаанд ашиглагдах хөрөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгөнд ороогүй бусад хөрөнгө оруулалтыг олж эзэмших болон худалдах үйл ажиллагааг хамарна.*" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авсан бараа материалын бэлтгэн нийлүүлэгчийг буруу бүртгэсэн	1	7,952.6			1	7,952.6	1	7,952.6				
Мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй илэрхийлсэн	1	7,276.3			1	7,276.3	1	7,276.3				
Санхүүгийн тайланд цалингийн зардлыг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаар тайлагнасан	1	4,960.8			1	4,960.8	1	4,960.8				
Дүн	**3**	**20,189.7**			**3**	**20,189.7**	**3**	**20,189.7**				

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1						1	
Дүн	**1**						**1**	